


Батлав. БОУАӨЯ-ны ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА.....Г.ЭНХМӨНХ

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“ШИВЭЭ ХҮРЭН ТЕРМИНАЛ” ХХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ.....Б.АНХБАЯР



ШИВЭЭ ХҮРЭН
ТЕРМИНАЛ

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАНТЭС СУМЫН БАГА-ОВОО БАГ,
“ЧИНГЭЛЭГТ ТЭЭВРИЙН ТЕРМИНАЛЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 3649245/

Хянасан:

Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын
газрын ахлах шинжээч..... /

Боловсруулсан:

“Хүрэн толгой коал майнинг” ХХК-ийн

Байгаль орчин, тогтвортой хөгжлийн
мэргэжилтэн / Б.Баярманлай /

2025 он

ГАРЧИГ

ГАРЧИГ	1
ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	3
1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл.....	4
1.2 Төслийн хүчин чадал	6
1.3 Үйл ажиллагаа явагдах ерөнхий зарчим	7
1.4 Төслийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл.....	11
1.5 Дэд бүтэц, үйл ажиллагаа	15
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	17
2.1 Түүхэн товчоон	17
2.2 Газар нутгийн онцлог.....	17
2.3 Эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд	17
2.4 Физик газарзүй, байгаль цаг уурын нөхцөл	17
2.5 Цаг агаарын төлөв байдал, олон жилийн төлөв	18
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	19
3.1 Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ	19
3.2 Хөрсөн бүрхэвч, газрын гадаргад нөлөөлөх байдлын үнэлгээ.....	19
3.3 Ургамалжилт	20
3.4 Усан орчин.....	20
3.5 Биологийн төрөл зүйл Ойр орчим ургамлын аймаг, ургамалжилт	20
3.6 Амьтны аймаг.....	21
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	22
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	24
5.1 Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	24
5.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ.....	25
5.3 Хөрс бохирдуулахгүй ариун цэврийн байгууламж буюу септик системтэй ариун цэврийн байгууламж ашиглах. Тоног төхөөрөмжийн бүрэн ажиллагаатай эсэхийг байнга хянах. Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	26
5.4 Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	26
5.5 Нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	27
5.6 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ	27
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	34
7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	37
8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	37

9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	39
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ).....	44
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	48
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	49
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ.....	50

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1-1 Төсөл хэрэгжих талбайн байршил.	6
Зураг 1-2 Төсөл хэрэгжих талбайн гэрэл зураг.....	6
Зураг 1-3 Мэдээллийн серверийн ажиллах схем.....	11
Зураг 1-4Төслийн ерөнхий төлөвлөлтийн зураг	12
Зураг 1-5. Ажилчдын байрны барилга угсралтын явц.....	12
Зураг 1-6 Ажилчдын амрах байрны төлөвлөлтийн зураг	13
Зураг 1-7. Шалган нэвтрүүлэх хяналтын хаалга	13
Зураг 1-8. Шинээр барьсан шалган нэвтрүүлэх хаалга.....	14
Зураг 1-9. Ариутгалын функт.....	14
Зураг 1-10. Цахилгаан дамжуулах шугамын зураг.....	15
Зураг 1-11 Авто замын зураг төсөл.....	16
Зураг 1-12 Авто замын хэсэг	16
Зураг 0-1 Төслийн талбайн орчмын сээр нуруутан.....	21
Зураг 6-1 Ногоон байгууламжийн төлөвлөгөө.....	34
Хүснэгт 1-1 Төслийн хувь эзэмшлийн байдал.....	4
Хүснэгт 1-2 Төсөл хэрэгжих талбайн координат	5
Хүснэгт 1-3 Аж ахуйн нэгжүүдийн терминалын талбай эзэмшлийн байдал	7
Хүснэгт 1-4 Төслийн ажиллах хүч.....	7
Хүснэгт 1-5 Контейнер тээврийн ачааны машины бүтээл	8
Хүснэгт 1-6 Уурхайгаас терминалын талбай хүртэл контейнер тээвэрлэх автомашины тоо	9
Хүснэгт 1-7 Богино зайн жолоочтой контейнер тээврийн ачааны машины бүтээл.....	9
Хүснэгт 1-8 Богино зайн жолоочтой контейнер тээврийн машины бүтээл	10
Хүснэгт 1-9 Богино зайн жолоочгүй контейнер тээврийн машины бүтээл.....	10
Хүснэгт 1-10 Төслийн барилга байгууламж.....	11
Хүснэгт 1-11Шинээр баригдах ариутгалын байрны солбицол.....	14
Хүснэгт 5-1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	33
Хүснэгт 6-1 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	36
Хүснэгт 0-1 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	38
Хүснэгт 0-1 Хог хаягдлийн менежментийн төлөвлөгөө.....	43
Хүснэгт 0-1 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	47
Хүснэгт 0-1 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	48
Хүснэгт 0-1 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	49
Хүснэгт 0-1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	50

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

1.1.1 Төслийн нэр:

“Чингэлэгт тээврийн терминалын талбай” төсөл

- ✓ Төслийн удирдагч: “Монголын алт” (МАК) ХХК
 - Улсын бүртгэлийн дугаар: 9011071054
 - Регистрийн дугаар: 3649245
 - Хаяг: Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, I хороо, XIX хороолол Чингисийн өргөн чөлөө, “Монголын Алт” (МАК) ХХК-ийн төв байр-44
 - Утас: 7575 9700

1.1.2 Төсөл хэрэгжүүлэгч:

- ✓ Хамтран хэрэгжүүлэгчид:

Хүрэн толгой коал майнинг ХХК, Өсөх зоос ХХК, Хур эрдэнэ баялаг ХХК, Жавхлант-Орд ХХК, Цагаан өвөлжөө ХХК, Сан транс ХХК, “Саусгоби Сэндс” ХХК, “ЕАИ” ХХК

Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 7-р сарын 02-ны өдрийн 185 дугаар тогтоолд улсын хилийн Шивээхүрэн боомтод Чингэлэгт тээврийн терминал байгуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг нүүрс экспортолж буй аж ахуй нэгжүүдийн санхүүжилтээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэхээр тогтоосон. Түүнчлэн Монгол Улсын Сангийн сайд, Хилийн боомтын үндэсний зөвлөлийн даргын 2021 оны 7-р сарын 30-ний өдрийн 21/05 дугаартай албан тоотод Шивээхүрэн боомтод чингэлэгт тээврийн терминал барьж байгуулах бүтээн байгуулалтын ажлыг Нарийнсухайтын бүлэг ордод үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий Монголын алт ХХК, Хүрэнтолгой коал майнинг ХХК, Өсөх зоос ХХК, Хур эрдэнэ баялаг ХХК, Жавхлант-Орд ХХК, Цагаан өвөлжөө ХХК, Саусгоби Сэндс ХХК, Сан транс ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд хамтран бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар гүйцэтгэхийг тогтоосон ба “МАК” ХХК удирдан ажиллахаар тогтоосон байна. Төсөл хамтран хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийн төслийн хувь эзэмшлийг Хүснэгт 1-1-д харууллаа.

Хүснэгт 1-1 Төслийн хувь эзэмшлийн байдал.

№	Аж ахуйн нэгжийн нэр	Хувь хэмжээ
1	“Монголын Алт” (МАК) ХХК	31.2%
2	“Хүрэнтолгой коал майнинг” ХХК	14.06%
3	“Өсөх зоос” ХХК	14.23%
4	“Хур эрдэнэ баялаг” ХХК	2.93%
5	“Жавхлант-Орд” ХХК	1.07%
6	“Цагаан өвөлжөө” ХХК	5.69%
7	“Саусгоби Сэндс” ХХК	1.85%
8	“Сан транс” ХХК	14.65%
9	“ЕАИ” ХХК	14.23%
Нийт		100%

1.1.3 Төслийн зорилго

Нарийнсухайтын бүлэг ордод үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүд 17 га талбайг хамрах чингэлэгт тээврийн талбай байгуулах төслийг доорх зорилгын дор хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Чингэлэгт терминал байгуулах зорилго:

- ✓ Нүүрсний экспортын орлогын 40 гаруй хувийг бүрдүүлдэг Нарийнсухайтын бүлэг ордоос экспортлох нүүрсний хэмжээг 10 сая тонноор нэмэгдүүлж, 24 сая тоннд хүргэх,
- ✓ Шивээхүрэн боомт нь тасралтгүй ажиллагаатай байдаг тул зөвхөн нүүрсээр

- ✓ тогтохгүй чингэлэгтэй бусад ачаа тээврийн эргэлтийг нэмэгдүүлэх,
- ✓ Ил задгай нүүрс буулгахаас зайлсхийн байгаль орчинд ээлтэй байх
- ✓ Хил дамнасан тээвэрлэлт хийж буй жолооч нарын эрүүл мэндийн аюулгүй байдал хангагдах,
- ✓ Нүүрсний хорогдол, бохирдол багасаж үнэ цэнээ алдахгүй байх,
- ✓ Эцсийн хэрэглэгчдэд нүүрс нийлүүлэх шинэ зах зээл бий болох зэрэг байна.

1.1.4 Төслийн талбайн байршил

“Чингэлэгт тээврийн терминалын талбай” төсөл нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 5-р баг буюу Бага-Овоо багийн нутагт хэрэгжихээр төлөвлөгдөөд байна. Төслийн талбай нь Нарийнсухайтын бүлэг ордын уурхайн талбайгаас 50 км зайд, Шивээхүрэн боомтоос 600 м зайд байрлана.


Төслийн талбайг төсөл хэрэгжүүлэхэд хамтрах аж ахуйн нэгжүүдийн нэг болох “Сан транс” ХХК-ийн эзэмшлийн 25 га талбай дотор 17 га талбайд үйл ажиллагаа явуулна. Тухайн талбайн шимт хөрсийг хуулан хашааг шилжүүлэн байрлуулж, талбайг тэгшилж шавар, хайрга дэвсэх ажлыг хийж дууссан байна.

“Сан транс” ХХК-ын эзэмшлийн 25 га талбай болон төслийн 17 га талбайн булангийн цэгүүдийн координатыг Хүснэгт 1-2-д орууллаа.

Хүснэгт 1-2 Төсөл хэрэгжих талбайн координат

Сан транс ХХК-ын эзэмшлийн талбайн координат		
№	X	Y
1	687225.65	4717461.44
2	677457.23	4718177.69
3	687916.42	4718066.62
4	689811.48	4718048.91
5	689565.23	4717357.11
6	687955.74	4717419.45
Төсөл хэрэгжих талбайн координат		
1	687405.159	4717879.188
2	688004.069	4717811.844
3	687973.642	4717540.421
4	687326.734	4717614.505

Төсөл хэрэгжих талбайн байршлын зургийг Зураг 1-1, Зураг 1-2-д харууллаа



Зураг 1-1 Төсөл хэрэгжих талбайн байршил.



Зураг 1-2 Төсөл хэрэгжих талбайн гэрэл зураг

1.2 Төслийн хүчин чадал

Чингэлэгт тээврийн терминалын талбайг 17 га талбайд байгуулах ба тухайн талбайд 4950 ширхэг (ачаатай-2475, хоосон-2475) контейнер багтах бөгөөд нийт 158.4 мянган тонн нүүрсний багтаамжтай байна. Нэг эгнээнд хамгийн ихдээ 6 контейнер байршуулах бөгөөд 2 талаас нь ачигч 3, 3 эгнээгээр 2 давхарлаж өрж хураахаар тооцсон. Уурхайгаас буюу ачилтын

талбайгаас чингэлэгт тээврийн машин ачигчаар нүүрс ачуулан гаалийн хяналтын талбай руу хоногт 87 автомашинаар 1044 чингэлэгт 33.3 мянган тонн нүүрсийг 24 цагаар 2 ээлжээр тээвэрлэнэ. Терминалын талбайд контейнер ачиж буулгах төхөөрөмжөөр ачаатай контейнер буулгаж хоосон контейнероо ачуулан буцаж уурхайн талбай руу явах зарчмаар жилд 300 хоног ажиллана.

Төслийн талбайд дээрх 9 аж ахуйн нэгжүүд 300-570 чингэлгээр тээвэрлэлт хийх бөгөөд төслийн нийт талбайн 9.8-18.4% хүртэлх хувийг компани тус бүр эзэмшинэ (Хүснэгт 1-3).

Хүснэгт 1-3 Аж ахуйн нэгжүүдийн терминалын талбай эзэмшлийн байдал

Компани	Давхар	Нийт чингэлгийн тоо	Компаниудад хуваасан байдал		
			Талбайд оногдох хэмжээ, мян.тн	Жилийн экспортын хэмжээ, мян.тн	Эзлэх хувь, %
“МОНГОЛЫН АЛТ” ХХК	3	574	18.36	1,500.00	15%
“SGS” ХХК	3	574	18.36	1,500.00	15%
“ӨСӨХ ЗООС” ХХК	3	574	18.36	1,500.00	15%
“ХҮРЭН ТОЛГОЙ КОАЛ МАЙНИНГ” ХХК	3	574	18.36	1,500.00	15%
САН ТРАНС	3	574	18.36	1,500.00	15%
“ХҮР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК	3	344	11.02	900.00	9%
ХҮР ЭРДЭНЭ БАЯЛАГ ХХК	3	306	9.79	800.00	8%
ЖАВХЛАНТ ОРД ХХК	3	306	9.79	800.00	8%
Нийт		3,825	122.4	10,000	100%
	Ачаатай	1,692			
	Хоосон	2,133			

1.2.1 Ажиллах хүч:

“Чингэлэгт тээврийн терминалын талбай” төсөл нь нийт 163 ажилтантай байх ба инженер техникийн ажилтан 57, уулын техникийн оператор 63, механик-засварчин 2, цахилгаанчин, гагнуурчин 2, туслах ажилчин 13, тогооч, бэлтгэгч 16, үйлчлэгч 10 байна. Төслийн талбайд ажиллах ажилчид төслийн дагуу бэлтгэгдсэн ажилчдын байранд байрлана (Хүснэгт 1-4)


Ажилтан	Хүний тоо
Инженер техникийн ажиллагсад	57
Уулын техникийн оператор	63
Механик-засварчин	2
Цахилгаанчин, гагнуурчин	2
Туслах ажилчин	13
Тогооч, бэлтгэгч	16
Үйлчлэгч	10
Нийт	163

Хүснэгт 1-4 Төслийн ажиллах хүч

1.3 Үйл ажиллагаа явагдах ерөнхий зарчим

Төсөл хэрэгжих ерөнхий зарчим нь монгол улсын нутаг дэвсгэр дэх Нарийнсухайтын бүлэг ордод үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлд бүхий аж ахуй нэгжээс нүүрс ачилт хийж Шивээхүрэн боомт дэх чингэлэгт терминалын талбайд хүргэнэ. Чингэлэгт терминалын

талбайд 158.4 мян.тонн хүртэлх бүтээгдэхүүнийг зөөвөрлөн БНХАУ-д хүргүүлэх хүртэл хадгалах боломжтой. Төслийн талбай дахь бүтээгдэхүүнийг хил гаалийн хуваарийн дагуу хэрэглэгчид хүргэснээр чингэлэгт тээврээр хийгдэх үйл ажиллагаа дуусгавар болно. Төслийн үйл ажиллагаа явагдах ерөнхий зарчмын талаар доорх хэсэгт дэлгэрэнгүй орууллаа.



Схем 1-1. Төслийн ерөнхий үйл ажиллагаа

1.3.1 Уурхайгаас чингэлэгт терминал хүртэлх ачилтын тооцоо

Өдрийн ээлжид нүүрс тээвэрлэсэн машин терминалын талбайн ачилт дуусахыг хүлээж 20 цаг хүртэл талбайн гадна зогсох тул өдрийн ээлжид 1 рейс, шөнийн ээлжид 2 рейс 24 цагт нийт 3 рейс хийхээр тооцсон. Мөн нэг контейнер тээврийн ачааны машин нэг рейс хийхэд нийт 5.9 цаг зарцуулах бөгөөд үүнд хоосон явах хугацаа 1.1 цаг, хоосон явах хурд 50 км/цаг, тээвэр хийх зай 50 км, буцах замын ачаалал 95%-тай, ачаатай явах хугацаа 3.6 цаг бөгөөд ачаатай явах хурд 30 км/цаг, тээврийн зай 50 км, явах замын ачаалал 65%-тай, терминалын талбайд хоосон контейнер ачуулах болон ачаатай контейнер буулгах хугацаа тус бүр 0.1 цаг, уурхайд нүүрс ачуулах, хучуулах, лацдуулах хугацаа 1 цаг байна. Түүнчлэн зөвхөн нүүрс тээвэрлэх хугацаа буюу тээврийн ачааны машин 3 рейс хийхэд 14.5 цаг ба хоногт 17 цаг нүүрс зөөхөд зарцуулж, цаг ашиглалт нь 85%-тай байна (Хүснэгт 1-5). Бетон замаар 3 эгнээ зорчих боломжгүй тул чингэлэг тээврийн машинууд энгийн тээврийн машинтай холилдож явна. Жилийн тээвэрлэлт хийж буй хугацаа нь 300 хоног байна.

Хүснэгт 1-5 Контейнер тээврийн ачааны машины бүтээл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Дүн
I	Нэг рейсийн хугацаа	цаг	5.9
II	Цэвэр нүүрс тээвэрлэх хугацаа	цаг	14.5
	2.1 Хоногт зөөх цаг	цаг	17.0
	2.2 Цаг ашиглалт	хувь	85%
III	Хоногт хийх рейс	рейс	3.0

Чингэлэг тээврийн талбайгаар жилд 10 сая тонн нүүрс экспортыг хийнэ гэж үзээд хоногт 33.3 мянган тонн нүүрсийг тээвэрлэхэд 87 машин (хоногт 1 машин 3 рейс

хийнэ) шаардлагатай ба нөөцөд байх машиныг 10 хувиар тооцож нийт 96 машинаар бүтээлийг хангаж ажиллана

Хүснэгт 1-6 Уурхайгаас терминалын талбай хүртэл контейнер тээвэрлэх автомашины тоо

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Дүн*
1	Жилд тээвэрлэх нүүрсний хэмжээ	тн	10,000,000
2	Жилд ачих хоног	хоног	300.0
3	Хоногт ачих нүүрсний хэмжээ (24 цаг)	тн	33,333
3	Хоногт хийх рейс	рейс	3
4	Нэг рейсийн бүтээл	тонн	128.0
5	Хоногийн бүтээл	тонн	384.0
6	Шаардлагатай машины тоо	ширхэг	87
7	Парканд (эвдрэл гэмтэл, засвар үйлчилгээ)	ширхэг	9
8	Нийт авах машины тоо	ширхэг	96

**Дээрх тооцооллыг "Монголын Алт" (МАК) ХХК-ийн тооцооллоор*

1.3.1 Чингэлэг терминалын талбайгаас БНХАУ хүртэлх ачилтын тооцоо

Чингэлэг терминалын талбайгаас контейнер ачих техникээр ачаатай контейнер ачуулж Шивээхүрэн боомтоор хоногт 1208 чингэлэг, (жолоочтой-860 чингэлэг, жолоочгүй-348) 38.5 мянган тонн нүүрсийг хил гаалийн хуваарийн дагуу 11 цагаар 1 ээлжээр тээвэрлэнэ. Баяр ёслол, амралтын хоногийг хасаж жилд 260 хоног ажиллахаар тооцсон. Чингэлэгт терминалын талбайгаас БНХАУ хүртэл чингэлэгт тээвэр нэг рейс хийхэд нийт 1.9 цаг зарцуулж байгаа бөгөөд үүнд хоосон явах хугацаа 0.08 цаг, хоосон явах хурд 20 км/цаг, тээвэр хийх зай 1.6 км буцах замыг ачаалал нь 100%-тай, ачаатай явах хугацаа 0.11 цаг, ачаатай явах хурд 15 км/цаг, тээвэрлэлт хийх замын урт 1.6 км, явах замын ачаалал 100%, хоосон контейнер буулгах болон ачаатай контейнер ачуулах хугацаа тус бүр 0.1 цаг, Монгол болон Хятадын хилээр орох, гарах, бүртгэл хийх хугацаа тус бүр 0.3 цаг, Хятад талд явах болон ачуулж буулгах хугацаа 1 цаг тус бүр байна.

Тус тээвэрт зөвхөн нүүрс тээвэрлэхэд 10.5 цаг зарцуулах ба нэг нүүрс тээвэрлэх ээлжид 11 цаг, цаг ашиглалт 95%-тай байна. Хил гаалийн хуваарийн дагуу өдрийн ээлжийн 11 цагт 1 машин 5 рейс хийхээр байна

Хүснэгт 1-7 Богино зайн жолоочтой контейнер тээврийн ачааны машины бүтээл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Дүн
I	Нэг рейсийн хугацаа	цаг	1.9
II	Цэвэр нүүрс тээвэрлэх хугацаа	цаг	10.5
	2.1 Ээлжид зөөх цаг	цаг	11.0
	2.2 Цаг ашиглалт	хувь	95%
III	Хоногт хийх рейс	рейс	5.0

Богино зайн жолоочтой контейнер тээврийн машин хоногт 19,200 тонн нүүрс, жилд 260 хоног 4,922,00 тонн нүүрс тээвэрлэлт хийнэ. Жолоочтой нэг машин хоногт 5 рейс хийж 640 тонн нүүрс тээвэрлэх чадамжтай ба нэг удаадаа 128 тонн нүүрс тээвэрлэнэ. Нэг контейнерын нүүрс багтаах хэмжээ нь 32 тонн бөгөөд нэг тээврийн машинд 4 ширхэг контейнер ачигдана. Богино зайн жолоочтой контейнер тээвэрт 30 ширхэг машин хэрэгтэй бөгөөд засвар, эвдрэл гэмтлийн онцгой тохиолдолд хэрэглэх нөөцийг 3 нийт 33 машин шаардлагатай.

Хүснэгт 1-8 Богино зайн жолоочтой контейнер тээврийн машины бүтээл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Дүн
1	Жилд нүүрс тээвэрлэх хэмжээ	тонн	4,992,000
2	Жил хил нэвтрүүлэх хоног	хоног	260
3	Хоногт хилээр гаргах шаардлагатай нүүрсний хэмжээ	тонн/хоног	19,200
4	Жолоочтой нэг машины хоногийн бүтээл (11 цаг) (4.1*4.2)	тонн	640
5	Шаардлагатай машины тоо	ширхэг	30
6	Парканд байх машины тоо (засвар, эвдрэл гэмтэл гэх мэт)	хувь	3
7	Нийт машины тоо	ширхэг	33


Харин богино зайн жолоочгүй контейнер тээврийн машин хоногт 19,262 тонн нүүрс, жилд 260 хоног 5,008,000 тонн нүүрс тээвэрлэлт хийнэ. Жолоочгүй нэг машин хоногт 19 рейс хийж 1,216 тонн нүүрс тээвэрлэх чадамжтай ба нэг удаадаа 64 тонн нүүрс тээвэрлэнэ. Нэг контейнерын нүүрс багтаах хэмжээ нь 32 тонн бөгөөд нэг тээврийн машинд 4 ширхэг контейнер ачигдана. Богино зайн жолоочтой контейнер тээвэрт 16 ширхэг машин хэрэгтэй бөгөөд засвар, эвдрэл гэмтлийн онцгой тохиолдолд хэрэглэх нөөцийг 2 нийт 18 машин шаардлагатай

Хүснэгт 1-9 Богино зайн жолоочгүй контейнер тээврийн машины бүтээл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Дүн
1	Жилд нүүрс тээвэрлэх хэмжээ	тонн	5,008,000
2	Жил хил нэвтрүүлэх хоног	хоног	260
3	Хоногт хилээр гаргах шаардлагатай нүүрсний хэмжээ	тонн/хоног	19,262
4	Жолоочтой нэг машины хоногийн бүтээл (11 цаг) (4.1*4.2)	тонн	1,216
5	Шаардлагатай машины тоо	ширхэг	16
6	Парканд байх машины тоо (засвар, эвдрэл гэмтэл гэх мэт)	хувь	2
7	Нийт машины тоо	ширхэг	18

Чингэлэг тээврийн талбайгаар жилд богино зайн жолоочтой контейнер тээврийн машин 10 сая тонн нүүрс экспортыг хийнэ гэж үзээд хоногт 38.5 мян.тонн нүүрсийг тээвэрлэхэд 33 жолоочтой машин, (хоногт 1 машин 5 рейс хийнэ) 16 жолоочгүй машин, (хоногт 1 машин 19 рейс хийнэ) шаардлагатай ба нөөцөд байх машиныг 10 хувиар тооцож нийт 51 машинаар тээврийг гүйцэтгэнэ. Тухайн машиныг нүүрс худалдан авагч тал хариуцаж ажиллана.

Түүнчлэн “Арш технологи” ХХК-тай иж бүрэн хяналтын систем нийлүүлж, угсарч суурилуулах гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Ингэснээр чингэлэгт тээврээр хийгдэх үйл ажиллагаа, пүүлэх, болон бүртгэл мэдээллийн үйл ажиллагаа бүрэн автомат болж тээврийн тэрэгний нэвтрэлт, дугаар зэрэг дата мэдээлэл төв мэдээллийн серверт бүртгэгдэж цааш гаалийн нэгдсэн системд очно.



Зураг 1-3 Мэдээллийн серверийн ажиллах схем


1.4 Төслийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл

1.4.1 Барилга байгууламж

Төслийн хүрээнд цаашид баригдах барилга байгууламжийг доорх хүснэгтэд орууллаа. Төслийн ерөнхий төлөвлөлтийн зургийг Зураг 1-4-д орууллаа. Төслийн ерөнхий төлөвлөлтийн зурагт зам талбай, контейнер ачиж буулгагч гэх мэт техник төхөөрөмж, авто пүү, ажилчдын байр, харуулын байр, шалган нэвтрүүлэх будка, ариутгалын байр, гүйдэг хаалт зэрэг барилга байгууламж, дэд бүтэц эрчим хүчний байгууламж төлөвлөгдсөн байна.


Хүснэгт 1-10 Төслийн барилга байгууламж

№	Барилга байгууламж	Тоо ширхэг, хэмжээ
1	Авто пүү	3
2	Авто пүүний байр	3
3	Харуулын байр /3м*3м/	2
4	Гүйдэг ухаалаг хаалт	4
5	Ариутгалын байр	4
6	Чиглэл заах самбар	6
7	AXIS Q6315-LE PTZ Network Camere загварын 360 градус эргэдэг камер, AXIS P1455-LE Network Camere загварын суурин камер	44
8	Бохирын байгууламж	1
9	Гэрэлтүүлгийн цамхаг	8
10	Хэрэглээний усны худаг	1
11	Ажил, амралтын 2 давхар, 1200 м ² талбай бүхий ажилчдын байр	1
12	Шалган нэвтрүүлэх будка	4




Зураг 1-4 Төслийн ерөнхий төлөвлөлтийн зураг

Төслийн талбайд гааль, хил хамгаалал болон мэргэжлийн хяналтын байгууллагын ажилчдын ажил, амралтын 2 давхар, 1200 м² талбай бүхий байртай. Ажилчдын байрны зургийг Зураг 1-5-д, байрны төлөвлөлтийн зургийг Зураг 1-6-д харууллаа.



Зураг 1-6. Ажилчдын байр.

ШИВЭЭХҮРЭН БООМТЫН ЧИНГЭЛЭГ ТЕРМИНАЛЫН ОФФИС, АМРАХ БАЙРНЫ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗУРАГ



Зураг 1-7 Ажилчдын амрах байрны төлөвлөлтийн зураг

Үүнээс гадна Хил Хамгааллын Ерөнхий Газар (ХХЕГ)-т иж бүрэн тоноглол бүхий 36.1 метрийн урттай, 2.7 метрийн өргөнтэй завь хэлбэртэй 2 ширхэг шалган нэвтрүүлэх хаалгыг хүлээлгэн өгсөн байна (Зураг 1-7).



Зураг 1-8. Шалган нэвтрүүлэх хяналтын хаалга

Шалган нэвтрүүлэх хаалганы суурийн бетон цутгалтын ажлыг Түмэн харш ХХК-аар гүйцэтгүүлэн будаж тохижуулан байрлуулсан байна (Зураг 1-8).



Зураг 1-9. Шинээр барьсан шалган нэвтрүүлэх хаалга

Өмнөговь аймгийн Онцгой комиссын даргын 2021 оны 5 дугаар сарын 11-ны өдрийн 390 тоот захирамжийн дагуу төсөл хэрэгжүүлэгч нь 10 ширхэг ариутгал халдваргүйжүүлэлтийн тоног төхөөрөмжийг (фunkt) байгуулах, суурилуулалтын ажлыг хийхээр шийдвэрлэсэн бөгөөд доор хүснэгтэд ариутгалын байрны солбицлыг харууллаа.

Хүснэгт 1-11 Шинээр баригдах ариутгалын байрны солбицол

Ариутгалын байрны солбицол	
Х	У
687148.0184	4717452.9715
687209.8063	4717432.4584
687203.3765	4717413.4659
687441.7200	4717433.9891

2024 оны байдлаар ариутгалын 9 ширхэг функт суурилуулсан ба 4 хаалганы ажил байгуулсан. Ариутгалын функтын ажлыг “Харү Констракшн” ХХК гүйцэтгэсэн. Ариутгалын функтын гэрэл зургийг Зураг 1-9-д орууллаа.



Зураг 1-10. Ариутгалын функт

1.5 Дэд бүтэц, үйл ажиллагаа

Усан хангамж: Төслийн хүрээд унд ахуйн усны хэрэглээг ажилчдын байрнаас 20 м зайд байрлах худгаас авч хэрэглэхээр төлөвлөсөн байна. Төслийн үйл ажиллагаанд цаашид худаг гаргаж ашиглах зорилгоор мэргэжлийн байгууллагаар худгийн уст цэгт тогтоох, геотехникийн судалгаа, хайгуул хийгдсэн.


Төслийн ус ашиглалтын тухайд чингэлэгт тээврийн терминалын талбай бүрэн хүчин чадлаараа ажиллахад нэг хүний өдөрт ашиглах усны хэмжээг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12-р хавсралтаар батлагдсан орон сууц нийтийн байр, гэр хорооллын усны хэрэглээний нормыг үндэслэн Ажилчдын ажиллах, амрах байранд байх нэг хүний усны хэрэглээний нормыг 150 литрээр, өдөрт ажиллах 50 хүний унд ахуйн хэрэгцээний усны хэмжээг доор үзүүлснээр тооцлоо. Үүнд:

Хоногт: $50 \text{ хүн} \times 150 \text{ л} = 7,500 \text{ л}$ буюу 7.5 м^3 Сард: $7.5 \text{ м}^3 \times 31$
хоног = 232.5 м^3

Жилд: $232.5 \text{ м}^3 \times 12 \text{ сар} = 2,790 \text{ м}^3$ ус хэрэглэхээр байна.

Цахилгаан хангамж: Ажилчдын ажиллах болон амрах байрны дулаан халаалтыг уурын зуухаар хангахаар төлөвлөсөн. Мөн хяналтын 44 камер, хөдөлгөөн зохицуулагч 3 гэрлэн дохио, хяналт шалгалтын 4 ширэг ухаалаг хаалга болон авто пүү зэргийг цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээнээс эрчим хүчээр хангана.


Шивээхүрэн гаалийн талбайн дэд станцаас 330 метр урттай цахилгаан дамжуулах агаарын шугам (ЦДАШ) татах ажил дууссан бөгөөд 35/6 дэд станц босгож, 6/0.4 кВ дэд станцын угсралт, холболтын ажил хийгдэж дууссан байна. Цахилгааны шугамын ажлын гүйцэтгэлийн байдлыг Зураг 1-12-д харууллаа. Мөн 35/6 дэд станцын бетонон 2 шон хуучин 4 ш талбайн гэрэлтүүлгийг шилжүүлэн босгож шинээр прожекторуудыг сольж хийсэн байна. Бусад тоног төхөөрөмж кабель материалууд захиалгын дагуу ирсэн байгаа бөгөөд угсарч холбох, монтаж хийхэд бэлэн болсон байна.



Зураг 1-11. Цахилгаан дамжуулах шугамын зураг.

Авто зам: Чингэлэгт тээврийн терминалын талбайн үйл ажиллагааны эхний хэсэг буюу уурхайн талбайгаас терминалын талбай хүртэл 48.2 км хатуу хучилттай замаар дээр дурдсан зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүд нүүрс тээвэрлэнэ. Үүний дараагаар богино


тээвэр буюу БНХАУ-ын хилээр нэвтрэхэд компани тус бүрээс хамаарч 4.35-5.2 км хатуу хучилттай замаар тээвэр хийхээр байна.



Зураг 1-12 Авто замын зураг төсөл

Төслийн хүрээнд бетон замын төгсгөлөөс гааль мэргэжлийн хяналтын байр хүртэл, Гааль, Мэргэжлийн хяналтын байрнаас Хилийн цэргийн хяналтын шалган нэвтрүүлэх байр хүртэлх зам болон Хилийн цэргийн хяналтын шалган нэвтрүүлэх байрнаас Монгол улсын хилийн зурвас хүртэлх зам зэрэг нийт 41,028 м² талбайд хатуу хучилттай зам тавиад байгаа бөгөөд энэ ажлын хүрээнд 13,129 м³ хөрсийг ухаж, 6,154 м³ хөрсийг далан дүүргэлтэд ашиглаж, 6,154 м³ хайрга дэвсэж, 25,437 м³ газар шорооны ажил хийсэн байна.

Тус замын ажил нь 1500 метр урт, 12 м өргөн замын далан бөгөөд 90 см өнгөн хөрс хуулж, шавар болон уурхайн тэсэлгээний чулууг хольж 2 үе 30:30 см-ээр дэвсэлт хийж индүүдэн, хайрган үеэр 30 см дэвсэлт хийж нягтаршуулсан байна (11).



Зураг 1-13 Авто замын хэсэг

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Түүхэн товчоон

Өмнөговь аймгийн Гурвантэс сум нь 1954 онд анх Тост нэртэйгээр одоогийн Сэврэй сумын 1 дүгээр баг, Ноён сумын 3, 4, 5 дугаар багууд нийлж Улаан толгой гэдэг газар 281 өрх, 943 хүн амтай, 63,2 мянган малтай байгуулагджээ. 1959 онд орон даяар нэгдэлжих хөдөлгөөн ялсаны үрээр, 1960 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар Гурвантэс сум гэж нэрлэгдэн, одоогийн байрлаж байгаад Уртын дэнжид төвлөрсөн байна.

2.2 Газар нутгийн онцлог

Тус сум нь 2.9 сая га газар нутагтай хойд, баруун, баруун урд талаараа Баянхонгор аймгийн Шинэ жинст, Баянговь, Баянлиг, зүүн, зүүн хойд талаараа өөрийн аймгийн Сэврэй, Ноён, урд талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эзний хошуутай хиллэж, Говь-Алтайн нурууны цаад цөлөрхөг бүсэд оршдог. Улаанбаатараас 870 км, аймгийнхаа төвөөс 320 км алслагдсан байгалийн үзэсгэлэнт газар ихтэй, цаашид аялал жуулчлал хөгжих бүрэн боломжтой газар нутагтай.

Сумын газар нутгийн ихэнх хэсэг нь олон сая жилийн өмнө амьдарч байсан аварга үлэг гүрвэлийн орон гэгдэх бөгөөд ховор нандин олдвороороо гадаад дотоодын эрдэмтдийн анхаарлыг татаж Зөвлөлт, Польш, Монголын палеонтологичид хайгуул шинжилгээ хийж тэдний ажил шинэ шинэ олдвороор баяжсанаар ирсэн юм. Энэхүү олдворууд нь Москва, Варшав, Улаанбаатар, Даланзадгадын музейд өнө эртний аварга динозавр болон сүндэрлэж чимэг болж байна.

Мөн сайн чанарын чулуун нүүрс, давсаар баялаг, алт, төмрийн хүдэр, барилгын сайн чанарын шохой, шохойн чулуу, төрөл бүрийн өнгийн шороон будаг болон гартаам, мана зэрэг үнэт чулуу элбэг тохиолдоно.

2.3 Эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд

Гурвантэс сум нь засаг захиргааны анхан шатны нэгж болох 5 багтай, эдийн засгийн гол суурь баазаа мал аж ахуйг болгон хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх эхлэлийг тавин ажиллаж байна. Тус сум нь 2018 оны байдлаар 4934 хүн амтай 187458 толгой малтай 1558 өрхтэй. Сумын төвд төсөвт 7 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас гадна холбооны салбар, банк, цаг уур, ШТС-ийн зэрэг хувийн хэвшлийн байгууллагууд ажиллаж байна. Сумаас 55 км-т орших Дундголын давсны уурхай, нөхөрлөл нь жилдээ 220 орчим тн давс олборлож борлуулдаг ба сумаас 25 км-т орших нүүрсний орд газарт уул уурхайн компаниуд нүүрс олборлон БНХАУ-д экспортолж байна.

Гурвантэс сум нь цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, цагдаагийн тасаг ажиллаж байна. 2005-2006 оны хичээлийн жилээс 8 жилийн дунд сургууль 11 жилийн сургалттай сургууль болон өргөжсөн. Мөн тус сумын нутагт хилийн цэргийн 0166 дугаар анги байрладгаас гадна “Шивээ хүрэн”-ийн хилийн боомт үйл ажиллагаа явуулж байна.

Холбоо харилцааны хувьд 2006 оны 11 сард мобикомын үүрэн телефон суурилагдан, хүн амын 70 орчим хувь нь гар утас хэрэглэж байна. БНХАУ-ын ӨМӨЗОрны хөрш аймгаас өндөр хүчдэлд холбогдсон, 24 цагийн гэрэл цахилгаантай.

2.4 Физик газарзүй, байгаль цаг уурын нөхцөл

Хүрэн толгойн нүүрсний ордын геологийн тогтоц Нарийнсухайтын нүүрсний орд нь Овоот хурлын грабен синклиналийн хойт жигүүрийг үүсгэж байгаа дээд палеозой-доод

мезозойн терриген тунамал хурдасны дунд илэрсэн байдгийг өмнөх судлаачид тогтоосон ч сүүлийн үеийн судлаачдын ажлуудаар түүний насыг бүр мезозойны дунд үед хамааруулах хандлага ажиглагдаж байна.

Манай нэртэй эрдэмтдийн Ноён сумын хотгорт ялгасан триасын хурдасны доод талд түүнийг эмжсэн байдлаар нүүрс агуулсан хурдас илэрсэн байдгийг дээд пермийн Дэлийншанд формацид хамааруулсан байдаг юм. Иймээс бид энэ үндэслэлээр Нарийнсухайтын нүүрс агуулсан хурдасыг жиших аргад тулгуурлан дээд пермийн Дэлийншанд формацид, түүнийг хучиж байгаа хурдасыг триасын үеийн Ноён сумын формацид тус тус хамааруулж үзлээ.

Физик газарзүйн мужлалын хувьд Алтайн уулархаг их мужийн Говь-Алтайн мужид хамаарна. Хойд талаараа Бумбын нуруу (2360 м), Тостын нуруу (2517 м), Тахилтын хяр (2316 м) гэсэн 30 км өргөнтэй 180 км үргэлжлэх уулсаар хүрээлэгдэн оршдог. Дээрх уулсаас эх авсан хуурай сайрууд байх ба зарим хэсэгтээ нилээд өргөн бөгөөд хэдэн арван км үргэлжилдэг бөгөөд урагш хил давтал уруу, хил давтал үргэлжилнэ.

Ордын дүүргийн хувьд харьцангуй өндөр 1525-1560 м. Төв Азийн гадагшаа урсгалгүй ай савд хамаарагдана. Тухайн жилийн цаг уур, хур тунадасны хэмжээнээс хамаарч усны горим ихээхэн хувьсамтгай бөгөөд их цас орж хайлах, үргэлжилсэн бороотой үед хэдэн арван км үргэлжлэх хуурай сайрууд түр зуурын ширүүн урсгалтай гол болж хувирах ба бороо зогсмогц урсац байхгүй болдог онцлогтой. Хагарлын гарал үүсэлтэй олон тооны булаг тохиолдох ба ихэнх нь мөн урагш урсгалтай бөгөөд элсэн доогуур шурган алга болдог. Хүн малын унданд гар хийцийн худаг хэрэглэдэг бөгөөд усны түвшин нь 1-2 м, заримдаа 5-7 метр байдаг байна.

2.5 Цаг агаарын төлөв байдал, олон жилийн төлөв

Монгол орны уур амьсгалын гол онцлог бол жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, энэ чанараараа агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас бага, уур амьсгалд өргөрөгийн болон өндрийн бүслүүрийн ялгаа тодорхой илэрдэг явдал юм. Монголд богино (VI сараас VIII сарын дунд хүртэл үргэлжлэх), хуурай зун, ихээхэн хүйтэн, урт (XI сараас IV сар хүртэл үргэлжлэх) өвөлтэй, хавар намрын улирлын үргэлжлэх хугацаа жилээс жилд өргөн хүрээнд хэлбэлздэг онцлогтой. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвөл $-15-20^{\circ}\text{C}$ хүйтэн, зун $+30+35^{\circ}\text{C}$ заримдаа $+40^{\circ}\text{C}$ хүрч халдаг. Нэгдүгээр сарын агаарын дундаж температур $-14-18^{\circ}\text{C}$,). Үнэмлэхүй их халуун нь $+28+44.0^{\circ}\text{C}$ хүрнэ. Говь цөлийн бүсэнд 150-50 мм орчим хур тунадас унах ба хур тунадасны 85% орчим нь жилийн дулаан улиралд /IV-IX сард/ үүнээс зөвхөн 7,8 дугаар сард 50-60% нь орно. Монгол оронд үүлшил бага, цэлмэг өдрийн тоо их, жилдээ 230-260 хоног байх тул жилдээ 2600-3300 цаг нар гийгүүлнэ. Монголын тал хээр, говь цөлийн бүс салхи ихтэй. Жилийн дундаж салхины хурд энэ бүс нутагт 4-6 м/с. Монгол орны нутгийн 41.3%-ийг эзлэх говь-цөлийн бүсэнд сул шороо элбэг, салхи ихтэй тул шороон шуурга олонтоо тохиолдоно. Энэ бүс нутагт жилдээ 30-100 өдөр, Монгол элсний өмнөд захад жилдээ 120 өдөр шороо хийснэ.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 5-р баг буюу Бага-Овоо багийн нутагт хэрэгжих “Чингэлэгт тээврийн терминалын талбай” төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй нөлөөллүүд голчлон барилгын үе шатанд үүсэхээр байгаа бөгөөд богино хугацааны шинж чанартай байна. Нарийнсухайтын бүлэг ордын уурхайн талбайгаас хатуу хучилттай замаар нүүрс тээвэрлэх тул тээврийн машины хөдөлгөөнөөс үүдэн тоос тоосонцор дэгдэж орчны агаарт бохирдол учруулахааргүй байна. Харин төслийн хүрээнд тээвэр хийж байгаа машин техникийн хөдөлгүүрийн ажиллагаанаас үүдэн агаар бохирдуулагч ялгарахаар байна.

Төслийг Нарийн сухайтын бүлэг ордоос нүүрс олборлож байгаа аж ахуйн нэгжүүд хамтран хэрэгжүүлэхээр байгаа бөгөөд эдгээр төсөл хэрэгжүүлэгчид нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Бага-Овоо-5 багийн нутаг дэвсгэрт 17 га талбайд чингэлэгт тээврийн терминалын талбайг нүүрс хадгалах, тээвэрлэх зорилгоор байгуулахаар төлөвлөөд байна. Төслийн талбайд 4950 ширхэг (ачаатай-2475, хоосон-2475) контейнер багтах бөгөөд нийт 158.4 мянган тонн нүүрсний багтаамжтай байна. Нэг эгнээнд хамгийн ихдээ 6 контейнер байршуулах бөгөөд 2 талаас нь ачигч 3, 3 эгнээгээр 3 давхарлаж өрж хураахаар тооцсон. Уурхайгаас буюу ачилтын талбайгаас чингэлэг тээврийн машин ачигчаар нүүрс ачуулан гаалийн хяналтын талбай руу хоногт 87 автомашинаар 1044 чингэлэгт 33.3 мянган тонн нүүрсийг 24 цагаар 2 ээлжээр тээвэрлэнэ.

Нүүрсийг уурхайн талбайгаас чингэлэгт тээвэр буюу дээд талаас бусад хэсэг нь битүү чингэлэгт ачиж, тусгайлан бэлдсэн терминалын талбайд чингэлэгтэй нь буулгах учир төслийн талбай орчимд нүүрснээс үүдэлтэй тоос тоосонцор бага үүсэхээр байна. Нүүрс тээвэрлэж байгаа чингэлгийн задгай хэсгийн нүүрсний нурмаг хэсэг салхинд хийсэж агаарын орчны бохирдуулж болзошгүй байна.

3.2 Хөрсөн бүрхэвч, газрын гадаргад нөлөөлөх байдлын үнэлгээ

Чингэлэгт тээврийн терминалын талбай төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй гол нөлөөлөл нь барилгажуулах үйл ажиллагаа болон хүнд даацын машин механизмын хөдөлгөөний нөлөөгөөр үүсэхээр байгаа бөгөөд барилгын ажлын явцаас үзүүлэх нөлөө богино хугацааны шинж чанартай байна. Чингэлэгт тээврийн терминалын талбай дахь үйл ажиллагааны үе шатанд үүсэж болзошгүй нөлөөллүүд нь нүүрс тээвэрлэлт, засварын үед шатах тослох материал асгарах, хог хаягдлын буруу зохицуулалт, хатуу хучилтгүй зам дээрх машин механизмын хөдөлгөөн, шингэн хаягдал буюу бохир усны буруу зайлуулалт зэргээс үүсэхээр байна. Төслийн хэмжээнд сард 775 кг хатуу хог хаягдал ялгарахаар байгаа бол 5,250 л шингэн хаягдал ялгарахаар байна. Үүнээс гадна уурхайн талбайгаас терминалын талбайгаас тээвэр хийж байгаа машин техникийн эвдрэлээс үүсэх эд анги болон жолооч нарын ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг ил задгай хаяснаас хөрсөн бүрхэвчид бохирдол үүсгэж болзошгүй.

3.3 Ургамалжилт

Монгол орны ургамал газарзүйн мужлалаар “Шивээ хүрэн терминал” ХХК-ийн талбай нь Алтайн өвөр говийн цөлийн тойрог, Алшаа говийн тойрог болон Говь-Алтайн уулын цөлөрхөг хээрийн гэсэн гурван тойрог хамаардаг учир ургамлын аймгийн хувьд дээрх тойргуудын ургамлын аймгуудын бүрдлийг агуулсан өвөрмөц онцлогтой бүс юм.

Төслийн нийт 17 га талбайд терминалын талбай, тээвэр хийх машины техникийн явах зам талбайг бэлтгэхээр төлөвлөсөн. Иймд уг талбай бүхэлдээ хатуу хучилт, цементтэй тул тухайн орчны ургамлан нөмрөг устахаар байна. Төслийн талбайд хийгдсэн 2020 оны ургамлын хээрийн судалгааны үр дүнгээс харахад ховор, нэн ховор ургамал бүртгэгдээгүй бөгөөд хүмүүнсэг ургамал элбэг тохиолдсон бөгөөд ургамлан бүрхэвч төсөл хэрэгжих нийт талбайн 8-16%-д байгаа нь халцгай газар зонхилж байгааг харуулж байна.

3.4 Усан орчин

Төслийн талбайн ойролцоо буюу Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Бага Овоо-5-р багийн нутагт гол мөрөн, нуур цөөрөм зэрэг гадаргын ус байхгүй. Усан орчинд шууд сөрөг нөлөөлөл үүсгэж болох үйл ажиллагаа нь богино хугацаанд барилгын ажилд болон урт хугацаанд ажилчдын ахуйн хэрэглээний ус ашиглах, дам нөлөөлөл үүсгэж болох үйл ажиллагаа нь шатах тослох материалын асгаралт, бохир усны буруу зохицуулалт зэрэг байна. Төсөл дээр ажиллаж байгаа ажилчдын ахуйн хэрэглээнээс 5,250 л бохир ус гарахаар байна (Бүлэг 1). Барилга угсралтын үед барилгын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа том оврын машины хөдөлгөөний улмаас хөрс суларч, талхлагдаж тоосжилт үүсэх магадлалтай тул 32,000 литр усны танкны багтаамжтай зам усалгааны машиныг барилга угсралтын ажил дуусах хүртэл түр хугацаанд хэрэглэнэ.


Төслийн хүрээнд ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах усыг “Алтай Эколог” ХХК-ын ханган нийлүүлж байгаа орчин үеийн орос технологи бүхий бие бохир ус цэвэрлэх байгууламжийг суурилуулах бөгөөд энэхүү байгууламжаар цэвэрлэсэн ус нь MNS 4943:2011 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир усны ерөнхий шаардлагыг бүрэн хангасан. Тиймээс цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдэн гарсан усыг зам усалгааны ажилд хэрэглэх боломжтой.

3.5 Биологийн төрөл зүйл Ойр орчим ургамлын аймаг, ургамалжилт

Ургамлан бүрхэвчийн тухайд цөл, цөлөрхөг хээрийн сөөг, сөөгөнцөр, заримдаг сөөг зэрэг цөлийн бүсэд дасан зохицсон монгол орны унаган ургамлууд зонхилон тархсан. Ургамалжилтийн зонхилох хэв шинж нь зүүн гарын улаан бударганат, хуурай сайрт шар хотир-монгол бүйлст- алтан харгана- улаан бударганат хэв шинжтэй байх бөгөөд өргөн хотгор, уст цэг, булгийн хужир, мараалаг, давстай чийгсэн газарт Сибирь хармаг, Гялгар дэрс, Гоолиг бадаргана, Ширэг улалж, ургасан байдаг.

3.6 Амьтны аймаг

Амьтны аймгийн бүрэлдэхүүний үндсэн хэсгийг говь цөлийн бүсийн амьтад бүрдүүлэх боловч тодорхой хэсгийг нь алтайн уулархаг газрын амьтад болох Аргал, Янгир, зэрэг ховор амьтад уулархаг газраар тохиолдоно. Уурхайн орчимд саарал чоно, үнэг, хярс, туулай, зэрэг хөхтөн амьтад, мөн могой, хонин гүрвэл, олон тооны шувууд байна.



Зураг 0-1 Төслийн талбайн орчмын сээр нуруутан

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Чингэлэгт тээврийн терминалын талбай” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11 сарын 1-ний дотор Гурвантэс сумын ЗДТГ-т танилцуулан, 12 дугаар сард багтаан БОАЖЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг БОАЖЯ-аар батлуулна.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг нөлөөлөлд өртөж болзошгүй байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзэж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг тооцсон болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулав.

БОМТ-г боловсруулахдаа Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”, 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг удирдлага болгов.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (Төрийн мэдээлэл, 2012 оны 22 дугаар) аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан. Хуулийн дээрх шаардлагын дагуу төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөрс болон ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах, усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, амьтны аймагт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах арилгах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн авч үзсэнийг Хүснэгт 6-2-т бүрэн эхээр харуулав. Төсөл хэрэгжүүлэгч энэхүү БОХТ-г бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, тэдгээрийг бууруулах, арилгах бүрэн боломжтой.

5.1 Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- БОМТ-ний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлж тоос, хорт хий, дэгдэмхий органик нэгдлийн хэмжилтийг хийж стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байх
- Барилга угсралт болон үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслийг хуваарьт үзлэгт оруулж, засвар үйлчилгээг тогтмол хийлгэж, холбогдох техникийн шаардлагыг хангасан тээврийн хэрэгслийг ашиглах. Машин, механизм, техник хэрэгслээс ялгарах хий, утаа зэргээс үүсэх сөрөг нөлөөллийг багасгахын тулд машин техникийн ашиглалтын явцад үзлэг, оношилгоонд оруулж, засвар үйлчилгээг шаардлагын дагуу хийж гүйцэтгэж байх, шаардлага хангахгүй байгааг нь шинэчилж, техникийн аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах, агаар бохирдуулсны төлбөрийг тогтмол төлж байх. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдох жилийн төлбөрийг жилд нэг удаа тухайн жилийн 6 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө харьяалах татварын албанд төлөх бөгөөд авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн техникийн үзлэгийн гэрчилгээ нь агаарын бохирдлын төлбөр төлсөн тухай тэмдэглэлтэй байна.
- Терминалын талбайд тээврийн машин зогсох зогсоолын талбайг бэлдэх хэрэгтэй бөгөөд түлш шаталтаас үүсэх агаар бохирдуулагчийг бага байлгах үүднээс зогсоолд зогссон машиныг хөдөлгүүрийг бүрэн унтрааж байх
- Барилгын ажлын үед болон шатах тослох материалын тээвэрлэлтийн үед машин механизмуудыг шаардлагагүй тохиолдолд олон салаа зам үүсгэхээс сэргийлэх, тээврийн хэрэгсэл болон ажилчдыг зөвхөн 1 тогтсон замаар явахыг зөвшөөрөх бөгөөд замгүй газраар зорчиж байгаа эсэхийг байнга хянах.
- Барилгын материал байршуулах талбайг зонхилох салхины чиглэлийг харгалзан салхин доор байрлуулах .
- Барилгын үед ашиглагдах, ил задгай хадгалагдах шаардлагатай барилгын материалуудыг (элс, хайрга, цемент г.м) салхи, хур тунадсаар зөөгдөхөөс хамгаалж хашаалах болон дээвэрлэх шаардлагатай.
- Төслийн талбайд тоосжилт үүсэхээс сэргийлэн салхины эрч ширүүссэн үед (10м/с-ээс дээш хурдтай үед) хөрс хуулалтын ажил явуулахгүй байх
- Хүнд машин механизм, авто машин зогсох талбай зэрэгт хөрсний эвдрэлээс агаарт тоосжилт үүсэхээс сэргийлж тухайн талбайнуудыг хатуу хучилтай болгох.
- Хатуу хучилтгүй замд автомашины хурдыг хязгаарлах (шороон замаар 30 км/цаг хурднаас хэтрүүлэхгүй явах, хатуу хучилттай замаар 60 км/цагийн хурдтай явах), тоосжилтыг бууруулах усалгааг хийх.
- Ажилчдын оффисын агааржуулалтын системийн ажиллагаа, агааржуулалтын хоолойн бүрэн бүтэн байдлын хяналтыг тогтмол хугацааны давтамжтайгаар хийж, тэмдэглэл хөтөлж байх
- Нүүрс тээвэрлэх чингэлгийг нүүрс ачих хэсэг буюу задгай талыг зориулалтын тор болон презентээр битүүлэх

- Ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг салхины зонхилох чиглэлийн дагуу, доод талд ус үл нэвтрэх дотортой, зориулалтын саванд түр хадгалан цуглуулах нь зүйтэй, мөн хогийн түр цэгт халдваргүйжүүлэлт, нян устгах ариутгалыг мэргэжлийн байгууллагаар тогтсон хугацаанд хийлгэж байх.
- Хог хаягдлыг шатаахыг хориглож ажиллах.
- Халаалт дулааны асуудлыг эрчим хүч бага зарцуулах технологи ашиглаж шийдэх
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан агаарын чанарыг хянах үзүүлэлтүүдийн дагуу хяналт мониторинг байгаль орчны мэргэжилтэн эсвэл мэргэжлийн байгууллагаар хийлгэх. Хяналт мониторингийн үр дүнг нэгтгэн дүгнэж төслийн үйл ажиллагаатай холбоо зөвлөмжийг боловсруулж, гарсан зөвлөмжийг дагаж мөрдөх шаардлагатай.

5.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Барилга баригдах талбайгаас гаднах талбайд орших ургамлыг талхагдалд оруулахгүй байх
- Тоосжилт нь ургамлын навчны амсрыг бөглөх, улмаар фотосинтезийн явцыг бууруулах, ургамлын ургалтыг доройтуулах тул тоосжилтыг бууруулах усалгааг хийж байх.
- Хатуу хучилтгүй замд автомашины хурдыг хязгаарлах (шороон замаар 30 км/цаг хурднаас хэтрүүлэхгүй явах, хатуу хучилттай замаар 60 км/цагийн хурдтай явах).
- Бүтээн байгуулалтын ажил дууссаны дараа хуулж хадгалсан шимт хөрсөө ашиглан МУ-ын Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-д заасны дагуу нийт эдэлбэр газрын 10%-тай тэнцэх талбайд ногоон байгууламж байгуулах, төслийн талбайн онцлогт тохируулан бут, сөөг, олон наст ургамал тарих, арчлах, тордох арга хэмжээг хэрэгжүүлэх.
- Хуулах шимт хөрсний хэмжээ, төрлийг тодорхойлох, хадгалах газрын байршлыг тогтоох
- Шимт хөрсийг бусад үе давхаргатай холилдохоос сэргийлэх зорилгоор хөрс хуулах гүн болон хөрс хуулах арга барилын талаар гэрээлэн гүйцэтгэгч компанид тодорхой зааварчилгааг өгөн, тохиролцож ажиллах.
- Барилгын ажлын үед болон түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэх явцад ашиглагдах тэврийн хэрэгслийг төслийн талбайн ойр орчмоор замгүй газраар явж хөрс эвдэж олон салаа зам үүсгэхгүй байх дээр анхааруулга өгч, зөвхөн 1 тогтсон замаар явахыг зөвшөөрөх.
- Төслийн талбай орчмын хөрснөөс намар, хаварт дээж авч чанарын шинжилгээг тогтмол хийлгэж байх.
- Хүнд машин механизм, авто машин зогсох талбай зэрэгт хөрсний эвдрэлээс агаарт тоосжилт үүсэхээс сэргийлж тухайн талбайнуудыг хатуу хучилттай болгох.
- Ажилчдыг засмал зам талбайгаар явахыг сануулсан тэмдэглэгээ байршуулах,
- Машин механизмын засвар үйлчилгээг хийх үед асгаралт үүсэх, хөрс бохирдуулахаас сэргийлэн зөвхөн хатуу хучилттай талбайд хийх ба шатах тослох материал, нефтийн бүтээгдэхүүний сав баглаа боодол, тостой даавуу сэлбэг хэрэгсэл (аккумулятор, хаягдал олгой, дугуй гэх мэт)-ийн хаягдлыг ил задгай хаяхгүйгээр зориулалтын цэгт хадгалж гэрээт байгууллагуудад хүлээлгэж өгөх.
- Хөрсөнд нефть бүтээгдэхүүн алдагдсан тохиолдолд бохирдсон хөрсийг хуулан тусгай талбай дээр хурааж, түүнийг 18-22%-ийн хлорт уусмалаар нэвчтэл норгож, уг хөрс шорооны нефть бүтээгдэхүүний агууламж 0.07 мг/кг-аас ихгүй, 4 этиль хар тугалганы агууламж 0.05 мг/кг-аас ихгүй болсон тохиолдолд байсан газарт нь буцааж хийж болно,
- Энгийн хог хаягдлыг хаягдлын санд цуглуулахдаа Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйл. Хогийн саванд тавигдах шаардлагад нийцүүлэн ангилах, ачих цуглуулах технологид нийцсэн, ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн байдлаар байгуулах,

- Хог хаягдлыг шатаахыг хориглож ажиллах.
- Бохир ус цэвэрлэх байгууламж, хогийн цэгийн байрлалыг хөрсний усны түвшин, гадаргын хэвлий зэрэгтэй уялдуулан зөв сонгох (объектоос 60м-ээс багагүй зайд, зонхилох салхины доод хэсэгт).
- Ажилчид болон тээврийн жолооч нарыг ил задгай бие засахыг хатуу хориглох. Ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг зориулалтын цэгт хуримтлуулах, тус цэгийг халдваргүйжүүлэх, нян устгах ариутгалын ажлыг мэргэжлийн байгууллагаар тогтсон хугацаанд хийлгэж байх.
- Төслийн үйл ажиллагаанд тээврийн хэрэгсэл, машин механизм ашиглана. Ашиглалтын явцад ШТМ-ын хог хаягдал гарах ба үүнийг аюултай хог хаягдал гэж үзнэ. Аюултай хог хаягдлыг савлах, хадгалах, тээвэрлэхдээ Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйл. Аюултай хог хаягдлыг савлах, 23 дугаар зүйл. Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалах, 24 дугаар зүйл. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх зэргийг мөрдлөг болгож ажиллах,

5.3 Хөрс бохирдуулахгүй ариун цэврийн байгууламж буюу септик системтэй ариун цэврийн байгууламж ашиглах. Тоног төхөөрөмжийн бүрэн ажиллагаатай эсэхийг байнга хянах. Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Усыг үр ашигтай хэрэглэх талаар ухуулга, сурталчилгааг барилгын болон засварын ажилчдад хийж мэдээллийн хуудсыг зохих газруудад байрлуулж шинэчилж байх, ажилчдын усны хэрэглээнд хяналт тавих.
- Ахуйн хэрэглээний ус ашиглалтад ус хэмнэгч цоргыг ашиглах
- Усыг зөвшөөрөгдсөн эх үүсвэрүүдээс хангах.
- Усны эх үүсвэрт худгийн усны чанарын хяналтыг тогтмол хийх
- Төслийн үйл ажиллагаанд цаашид худаг гаргаж ашиглах тохиолдолд мэргэжлийн байгууллагаар худгийн уст цэгт тогтоох, судалгааг хийлгэх
- Машин механизм, тээврийн хэрэгслээс бензин, тос тосолгооны материалын асгаралт алдагдал үүсэж усан орчинг бохирдуулахаас сэргийлж машин техникийн засвар үйлчилгээг зөвхөн тогтоосон хатуу хучилттай талбайд хийх.
- ШТМ асгаралт болсон тохиолдолд ашиглах саармагжуулах хэрэгслийг байрлуулах.
- Шатах тослох материал, нефтийн бүтээгдэхүүний сав баглаа боодол, тостой даавуу сэлбэг хэрэгсэл (аккумулятор, хаягдал олгой, дугуй гэх мэт)-ийн хаягдлыг ил задгай хаяхгүй байх
- Бохир усыг зайлуулах шугамын бүрэн бүтэн байдлыг хянах, засварлах (байгалийн аюулт үзэгдлүүдийн дараа).

5.4 Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж

- Барилгын ажлын үед барилгын материал зөөвөрлөх автомашинуудыг тогтсон замаар зорчуулах.
- Хатуу хучилтгүй замд автомашины хурдыг хязгаарлах (шороон замаар 30 км/цаг хурднаас хэтрүүлэхгүй явах, хатуу хучилттай замаар 60 км/цагийн хурдтай явах).
- Эвдэгдэх талбайг аль болох бага байлгах талаар барилгын ажилчдад сургалт хийх.
- Өнгөн хөрсөнд агуулагдах нутгийн ургамлын амьдрах чадварыг нь хэвээр хадгалахын тулд өнгөн хөрс хуулалт, хадгалалтын стандартыг мөрдөж ажиллах.
- Барилгын ажлын үеэр барилгын хог хаягдлыг цаг тухайд нь цэвэрлэх, зайлуулах.
- Чингэлэгт тээврийн терминалын талбайн ногоон байгууламжийн талбайд тухайн бүс нутагт ургадаг ургамлын төрөл, зүйлүүдийг ашиглах.

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж

- Хууль бус агнуур хийх, амьтны үр зулзага, өндөг, үүр нүх сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад анхаарч байх
- Ан амьтны тухай хууль, тогтоомжийг чандлан биелүүлж ажиллах
- Төслийн талбай болон түүний ойр орчмын нутгуудад амьтдын мониторинг явуулахТөслийн талбай түүний ойр орчмын хогийн цэг дээр амьтан тэжээл хайж ирэх, орогнох, үүрлэх нөхцөл үүсгэхгүй байх, ахуйн хог хаягдлаас мал амьтан хордож болзошгүй учир үүнээс сэргийлж хог хаягдлыг ангилан зориулалтын битүү саванд байршуулах хэрэгтэй.
- Ажилчдын орон байр, амрагчдын сууцад элдэв мэрэгчид, шувуу, шавж элбэгших явдлыг хянах, хүн малын халдварт өвчин гарах, дэлгэрэхээс сэргийлэх
- Төслийн талбайд мал амьтан орж, машин механизмд дайруулж хорогдохоос сэргийлж, байнгын хараа хяналт тавих
- Мал, амьтныг зам хөндлөн гарахад зориулсан гарам, гарцтай болгох
- Нефть, нефтийн бүтээгдэхүүн болон бусад хортой бодис асгарах, гоожих тохиолдолд орчны хөрс, ус, ургамал, амьтан хөнөөгдөх аюултайг байнга анхаарч хяналт үзлэг үйлчилгээг тогтмол хийж байх;

5.5 Нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Барилгын ажлын үед аюулгүй зайнуудыг тогтоож, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулан энэ тухайгаа орон нутгийн иргэдэд сурталчлан таниулж, тэдний ухамсрыг дээшлүүлснээр эрсдэл буурна.
- Хамгаалах хэрэгсэлгүй хувь хүнийг ажлын талбай руу зөвшөөрөлгүй орохыг хориглож хяналт тавина.Төслийн ажилчдыг хөдөлмөрийн хамгаалах хувцас хэрэгслээр бүрэн хангаж, хэрэглүүлж хэвшүүлэх, түүнд хяналт тавих.
- Төслийн бүх ажилчдад ажил үүргийн хуваарьтай нь уялдуулан аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч сургалтад хамруулж байх.
- Ажилчдад болзошгүй аваар ослын үед анхны тусламж үзүүлэх сургалт зааварчилгааг өгөх
- Анхны тусламжийн хайрцгийг ажлын талбайд бэлэн байлгах.
- Барилгын ажлыг өдрийн цагаар буюу 07:00-22:00 цагийн хооронд гүйцэтгэх шаардлагатай. Хэрэв шөнийн цагаар ажиллах шаардлагатай бол орон нутгийн удирдлагуудад мэдэгдэж, ойролцоо амьдардаг иргэдэд мэдээлэл хүргүүлэх.
- Агаарын чанараас шалтгаалан нийгэмд үзүүлэх дам нөлөөллийг бууруулахын тулд тайлангийн 3.1-д заасан агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх.
- Төслийн ажилчид болон орон нутгийн иргэдээс гомдол санал ирсэн тохиолдолд хүлээн авч цаг алдалгүй зохих шатанд нь шийдвэрлэж хариу өгч байх.
- Ажилчдын ахуйн хэрэглээний усыг цэвэршүүлж ашиглах

5.6 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 101 дүгээр зүйлд заасны дагуу Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жилд тутам хийлгэх.
- Газрын төлөв байдлын хянан баталгааг 5 жил тутамд хийлгэх.
- Шинээр байшин барилга барих, шинэчлэх, өргөтгөх болсон тохиолдолд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т заасны дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийлгэнэ. /нэмэлт тодотгол/.
- Тайланд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн

санхүүгийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх.

- Энгийн хог хаягдал тээвэрлэх гэрээний хугацаа дууссан тохиолдолд тухай бүрд сунгаж ажиллах.
- Төслийн талбайгаас хог хаягдлыг тээвэрлэн Гурвантэс сумын хог хаягдлын төвлөрсөн цэгт стандарт, шаардлагын дагуу хаяж буй талаар сум орон нутгийн иргэдэд тогтмол тайлагнаж мэдээлж байх Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу гамшгаас хамгаалах төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, холбогдох даатгалд хамрагдах;. Гамшгийн эрсдэлийн үнэлгээг 3 жил тутам, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгохтой уялдуулан тухай бүр хийнэ.
- Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл (газар хөдлөлт, үер, хүчтэй салхи, хүчтэй шуурга) болоход гэмтэж бэртэхээс урьдчилан сэргийлж, ажиллагсдыг сургалтад хамруулж дадлагажуулах, эмнэлгийн анхны тусламжийн хайрцгийг талбайд байрлуулах.
- Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг хатуу хориглох.
- Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах.
- Ажил олгогч нь ажилчдыг жилд 1 удаа эмнэлгийн урьдчилсан үзлэгт хамруулна. Эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцна.
- Ажиллагсдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар мэдлэг олгох сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах.
- Ажил олгогч нь ажилтнуудын ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах.
- Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн чанарын талаар мэргэжлийн байгууллагаар ажил олгогч дүгнэлт гаргуулах.
- Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ болон Өмнөговь аймгийн ЗДТГ-т хүргэн өгч байх
- Улс, орон нутгийн төсөвт төлөх татвар хураамжийг цаг тухайд нь төлөх.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгж зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
Агаарын чанар									
1	Хөрс хуулалт газар шорооны ажил явагдсанаар орчны агаарт тоосжилт үүсэх	10 м/с-ээс дээш хүчтэй салхитай үед газар шорооны ажлыг түр зогсоох	Төслийн хүрээнд	га	-	-	Зардал гарахгүй	Салхины хүч ихээр нэмэгдэх үед	MNS ISO4227-2002 Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS 5885-2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 4990-2000 ХААЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй
2	Машин механизмаас ялгарах хорт утаа нь агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Ашиглагдаж буй машин техникийг үзлэгт хамруулах, агаарын бохирдлын төлбөрийг төлөх	Төслийн хүрээнд	Жил	ҮАЗ	1	ҮАЗ	2025 онд Жилд 1 удаа	
3	Барилга угсралтын явцад тоосжилт үүсэх	Барилга байгууламж барих үйл ажиллагааны явцад тоосжилт үүсгэж болзошгүй бараа материалыг зөв битүү эсвэл зориулалтын аргаар зөөж тээвэрлэх, 10 м/с-ээс дээш хүчтэй салхитай үед дээрх бараа материалыг хянах, тоос дэгдэхгүй байх талаас нь арга хэмжээ авах	Төслийн хүрээнд	-	ҮАЗ	-	-	Барилгажуулалтын үйл ажиллагаа явагдах хугацаанд салхины хүч ихээр нэмэгдэх үед	
4	Нарийн сухайтын бүлэг ордын уурхайн талбайгаас төслийн талбай хүртэл болон төслийн талбай дотор үйл ажиллагаа явуулах машин техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Нарийн сухайтын бүлэг ордын уурхайн талбай хүртэл хурдны хязгаарлалтын болон олон салаа зам гарахаас сэргийлэх тэмдэглэгээ байршуулах, хурдыг хянах	Төслийн хүрээнд	Жил	-	Өдөр бүр	ҮАЗ	Жилд 1 удаа хийж гүйцэтгэж цаашид хянах	

	Барилгын материал, ажиллах хүч, тоног төхөөрөмжийг төслийн талбай руу тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн түлшний шаталтаас CO, SO2, NOx болон PM10 зэрэг агаар бохирдуулагчид ялгарна.	Төслийн талбай дотор, тээврийн зам дагуу, хог хаягдлыг цэг орчимд болон тээврийн машины зогсоолын орчимд агаарын бохирдуулагч хэмжих цэг байгуулж, тогтмол хэмжиж байх	Төслийн хүрээнд	Жилд	300.00	1	300.0	2025 онд жилд нэг удаа	автомашин. Утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй
5	Тээврийн чингэлэгт задгай хэсгээр нүүрсний нурмаг хэсэг тээвэрлэлтийн явцад хийсэж орчны агаар бохирдуулах	Чингэлгийн задгай хэсгийн зориулалтын тор эсвэл брезентээр хучих	Төслийн хүрээнд, засварын талбай	-	ҮАЗ	-	-	2025 онд жилийн турш	
Усан орчин (Гадаргын болон газрын доорх)									
1	Барилгын үе болон ажилчдын хэрэглээнд гүний ус ашигласнаар усны нөөц нөлөөлөх	Усыг үр ашигтай хэрэглэх талаар ухуулга, сурталчилгааг ажилчдад хийх, мэдээллийн хуудсыг хяналтын зарын самбарт, нийтийн бие засах газар байрлуулж шинэчилж байх	Төслийн хүрээнд	-	70.0	4	280.0	Улиралд нэг удаа	Усны тухай хууль болон холбогдох дүрэм журам
2	Усыг зөвшөөрлийн бус эх үүсвэрээс, эрүүл мэндийн шаардлага хангаагүй ус хэрэглэх болон усны эх үүсвэртэй зүй зохисгүй харьцаж гачигдал, бохирдол үүсгэх	Төслийн үйл ажиллагаанд цаашид худаг гаргаж ашиглах тохиолдолд мэргэжлийн байгууллагаар худгийн уст цэгт тогтоох, судалгааг хийлгэх	Төслийн хүрээнд	-	ҮАЗ	-	-	2025 онд	


Газрын гадарга, хэвлий болон хөрсөн бүрхэвч									
3	Шатах, тослох материал нефтийн бүтээгдэхүүн алдагдах, асгаралт үүссэнээр хөрсөн бүрхэвч бохирдох	ШТМ асгарах, алдагдах үед ашиглах хувийн хамгаалах хэрэгсэл, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд байрлуулах. /элс хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг/	Төслийн хүрээнд	-	600.0	1	600.0	Гүйцэтгэлээр	MNS 5914:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 3297-1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм Хог хаягдлын тухай хууль
4	Доторлогоогүй бохирын нүх ашиглахад хөрсөнд нян, хөгц, мөөгөнцрийн бохирдол үүсэх.	Бохирын септик систем ашиглах,Шингэн хаягдал хаях цооног /септик танк/ дах бохирдлын хэмжээг хянах, хэмжээ дүүрсэн үед соруулах	Төслийн хүрээнд	-	-	-	-	Үйл ажиллагаан ий үед тогтмол	Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм Хог хаягдлын тухай хууль
5.	Ажилчид засмал зам талбайгаар яваагүйн улмаас хөрс талхлагдах	Ажилчдыг засмал зам талбайгаар явахыг сануулсан тэмдэглэгээ байршуулах	Төслийн хүрээнд,	-	50.0	Тухай бүрт	50.0	2025 онд жилийн турш	
6	Шимт болон шимэрхэг хөрс талхлагдах, шимт хөрснийг технологийн дагуу бус хуулах хадгалах, хөрсний бусад үе давхаргатай холих зэргээс үүдэн шимт чанараа алдах	Төслийн газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах, хадгалахдаа MNS5916:2008, Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт , хадгалалт стандартыг хангах болон хөрс хуулах арга барилын талаар гэрээлэн гүйцэтгэгч компанид тодорхой зааварчилгааг өгөн, тохиролцож ажиллах. Шимт хөрс хуулалт, хадгалалтын үед гео-мэдээллийн сан хөтөлж, бүртгэх	Төслийн хүрээнд	га	ҮАЗ	Тухай бүрт	ҮАЗ	2025 онд жилийн турш	MNS5916:2008, Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт , хадгалалт стандарт

Биологийн олон янз байдал									
5.	Чингэлэгт тээврийн терминалын талбай байгуулж хатуу хучилттай болгосноор ургамлан нөмрөг устаж шууд нөлөөлөлд өртөнө	Ховор, нэн ховор ургамалд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлохын тулд ажиглалт судалгаа хийх, мэдээлэл цуглуулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах	Төслийн хүрээнд,	-	200.0	-	200.0	Барилга угсралтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө	MNS 5918:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага”.
	Амьтан дуу чимээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, гэрлийн нөлөөгөөр байршиж буй газар нутгаасаа үргэх, дайжих; мөн төслийн барилга байгууламж цаашид өргөжин тэлэх явцад амьдрах орчны шууд хомсдол, хуваагдалд орох	Ховор болон нэн ховор амьтад, тэдгээрийн нүүдэл, шилжилт хөдөлгөөн, мөн төслийн талбайн дотор болон гадна анхаарал болгоомжтой зорчих	Төслийн хүрээнд,	Улирал	300.0	1	300.0	Оны эхний улиралд багтаан тээврийн бүх ээлжийн жолооч нарыг хамруулах	
6.	Амьтад тээврийн хэрэгсэлд дайруулан үхэж, хорогдох эрсдэлтэй	- Уурхайгаас төслийн талбай хүртэлх тээвэрлэлтийн замд мал амьтан сэргийлэн тэмдэг тэмдэглэгээ тавих, жолооч нарт эрсдэлт газруудын байршлыг мэдээлэх, мал амьтан дайрагдсан тохиолдолд авах арга хэмжээний зааварчилгаа өгөх - Зэрлэг ан, амьтдын шилжилт хөдөлгөөнд саад учруулж буй хэсгүүдийг олж тогтоон анхааруулах арга хэмжээ авах	Төслийн хүрээнд	-	50.0	4	200.0	Жилийн турш, шинээр ажилд буй бүх ажилчид сургалтанд хамрагддаг	Амьтны тухай хууль
	Нийт зардал: сая/төг						1.93		

Хүснэгт 5-1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Чингэлэгт тээврийн терминалын талбай төсөл нийт 17 га талбайд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байна. Газрын тухай хуульд газар эзэмшигч нь эзэмшлийн талбайн талбайн 10 хувиас багагүй талбайд ногоон байгууламж байгуулахаар тусгагдсан байна. Иймд төслийн хэрэгжилтийн эхний шатанд төсөл хэрэгжих талбайн 10 хувь буюу 1.7 га-д мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар ногоон байгууламж байгуулахаар төлөвлөсөн. Доорх Зураг 6-1-д ногоон байгууламжийн төлөвлөгөөг эхний байдлаар төлөвлөсөн байгааг харууллаа. Уг төлөвлөгөөний дагуу ажилчдын байрыг тойруулан нийт 3460 м2 талбайг зүлэгжүүлж, сайжруулсан замын 2 талаар болон хашаа дагуулан нийт 1,0803 ширхэг мод тарихаар төлөвлөсөн байна.



Зураг 6-1 Ногоон байгууламжийн төлөвлөгөө

Цаашдаа Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилгаар орон даяар өрнөж байгаа “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн талбайн 15% буюу 2.55 га талбайд мод болон олон наст ургамал тарьж, зүлэгжүүлэх, бут тарих ажлыг хийж гүйцэтгэхийг санал болгож менежментийн төлөвлөгөөнд тусаж байна.

Тоосжилтыг бууруулж, гадаад үзэмжийг сайжруулах зорилгоор задгай талбай бүхий хэсэгт ногоон байгууламж, бут суулгасан хөрсийг бордох, сайжруулах ажлыг төлөвлөв. Үүнд:

1. Ургамал тарих, суулгах талбайн хөрсийг бордох, хөрсний чанарыг сайжруулах
2. Ажилчдын тухлах орчинтой холбоотойгоор ногоон байгууламж төлөвлөх. Ногоон байгууламжийг төлөвлөхдөө цэцэрлэгжүүлэлтийн чиглэлийн мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах, мэргэжлийн хүмүүсийн тусламжтай бутны суулгац тарьж ургуулах нь зүйтэй.
3. Ногоон байгууламжийн ургалтад анхаарал, хяналт тавих, усалгаа, арчилгаа байнга хийх, хүнд машин механизм болон хүний үйл ажиллагаагаар хугарч гэмтэх, халцарч, зулгарахаас хамгаалах арга хэмжээг авах, ногоон байгууламжийн орчимд хаалт, хамгаалалт тавих

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Ногоон байгууламж байгуулах	Төслийн нийт талбайн (17га) 10 хувиас багагүй талбайд үрэлгээ хийж, бут сөөг тарьснаар орчны өнгө үзэмжийг сайжрууж тохижуулах	Төслийн нийт талбайн (17 га) 10 хувиас багагүй талбайд (2.55 га)	м ²	25,500 м ²	-	2	2025 онд тарьж ургамалжуулах	MNS5916-2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”, MNS 5914:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт
Ногоон байгууламжийн арчилгаа						3	2025 онд тарьсан ургамал арчлах	
Нийт зардал	5,000,000 ₮							

Хүснэгт 6-1 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. Гэвч барилга, газар шорооны ажлын явцад соёлын өв олдохыг үгүйсгэж болохгүй. Тиймээс үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сумын бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

Хэрэв үйл ажиллагааны явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу арга хэмжээ авах үйл ажиллагааг түр зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагаар, олдворыг гэмтээхгүйгээр авран хамгаалах малтлага судалгааг хийлгэх нь зүйтэй.

8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Чингэлэгт тээврийн терминалын талбай төслийн үйл ажиллагааны явцад гэнэтийн осол эрсдэл гарахаас сэргийлж ажиллах шаардлагатай. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд урьдчилсан байдлаар тооцооллоо.

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгж зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Байгалийн гамшигт үзэгдлүүд	Эрх бүхий байгууллагаар Гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийлгэх.	Төслийн хүрээнд	-	Үйл ажиллагааны зардлаас		3 жил тутам, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгохтой уялдуулан тухай бүр	Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолын хавсралт Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам Гамшгаас хамгаалах тухай хууль
2	Газар хөдлөл	Орон нутгаас зохион байгуулах газар хөдлөлийн аюулын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөний талаарх мэдлэг өгөх сургалт хөтөлбөр болон турших дасгал сургуулилалтад ажилчдыг хамруулах	Төслийн хүрээнд	-			2025 онд жилд 1 удаа	Гамшгаас хамгаалах тухай хууль

3	Халдварт өвчин	Хоолны газрын эрүүл ахуйг сахиулах, ажилчдын хувийн эрүүл ахуйг сахих дадал зуршлыг хэвшүүлэх талаар мэдээлэл олгох сургалт зохион байгуулах	Төслийн хүрээнд	-	100,000	2025 онд жил 1 удаа	MNS 4992:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 16.1.7 MNS 5566:2020 Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн
4	Үйл ажиллагааны осол гэмтэл	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Төслийн хүрээнд	-	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны туршид	
5		Бүх ажилчдад ажил эхлэхийн өмнө хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, хамрагдаагүй ажилчдыг тухайн өдөрт ажиллахыг хориглох	Төслийн хүрээнд	-	Зардал гарахгүй	Үйл ажиллагааны туршид өдөр бүр	
6	Тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл гарах	Тоног төхөөрөмжийг тогтмол шалгаж засвар үйлчилгээг тогтмол хийх, бүртгэл хөтлөх.	Төслийн хүрээнд	-	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны туршид тогтмол	
	Нийт зардал:	0.1 сая/төг					

Хүснэгт 0-1 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Чингэлэгт тээврийн терминалын талбай төслийн үйл ажиллагаанаасаа гарч буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах 3R зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай.

Хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг бууруулахад менежментийн төлөвлөгөөний 5 жилийн хугацаанд 10,550,000₮ буюу арван сая таван зуун тавин мянган төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2017/ болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/443 дугаар тушаалаар батлагдсан “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”, Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 9/8 дугаар тогтоолоор баталсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-д тус тус зааснаар төсөл хэрэгжүүлэгч “Монголын Алт (МАК)” ХХК нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- ❖ Хог хаягдлаа эрх бүхий байгууллагаар “Хог ачиж, тээвэрлүүлэх гэрээ”-ний дагуу ангиллын төрөл тус бүрээр нэгдсэн хогийн цэг рүү ачуулах
- ❖ Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад гэрээ байгуулан шилжүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх
- ❖ Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр 180 хоногоос дээш хугацаанд түр хадгалах тохиолдолд тусгай зөвшөөрөл авч, түр хадгалахдаа Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 33-р зүйлд заасан шаардлагыг баримтална.
- ❖ Байгууллагын ажилтнуудад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх;
- ❖ Орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар, зам талбайн хог хаягдал, шарилж, лууль зэрэг хог ургамал, цас мөсийг тогтмол цэвэрлэх;
- ❖ Бүх нийтийн их цэвэрлэгээнд ажилтан, албан хаагчдыг хамруулах, холбогдох зардлыг гаргаж цэвэрлэгээний багаж хэрэгслээр хангах;
- ❖ Бүх нийтийн их цэвэрлэгээний өдрүүдэд орон нутгийн захиргаанаас зураглалаар хариуцуулсан нийтийн эдэлбэр газар, гудамж, зам, талбайн хог хаягдлыг цэвэрлэж, холбогдох байгууллагад хүлээлгэж өгөх
- ❖ Энгийн хог хаягдлыг хамгийн багадаа 3 төрлөөр ангилна
Үүнд:
 1. Дахин боловсруулах боломжтой
 2. Дахин боловсруулах боломжгүй
 3. Хүнсний органик хог хаягдал гэж төрөлжүүлэн эх үүсвэр дээр ангилан ялгах;
- ❖ Картон цааснаас бусад төрлийн ангилсан хаягдлыг зориулалтын уутанд хийж, уутны амыг боож битүүмжлэн шаардлага хангасан хогийн сав, бункерт байршуулан хадгалах ба хог ачиж цуглуулах хуваарийн дагуу ангиллын төрөл тус бүрээр хог тээврийн авто машинд ачуулах;
- ❖ Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах төрлийг хог хаягдал дахин боловсруулах үйл ажиллагаатай уялдуулан төсөл хэрэгжүүлэгч өөрийн санаачилгаар нэмэгдүүлэх

- ❖ 0,75 м³-с дээш эзлэхүүнтэй овор хэмжээ их энгийн болон барилгын хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3-д заасны дагуу нэмэлт үйлчилгээний хөлс төлж эрх бүхий мэргэжлийн байгууллагаар тээвэрлүүлэх;

	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая/төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая/төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Хог хаягдал түр хадгалах цэг орчимд тогтмол ариутгал, цэвэрлэгээ хийх	Төслийн хүрээнд	Жилд	-	12	Үйл ажиллагааны зардлаас	2025 онд тогтмол сард нэг удаа	Хог хаягдлын тухай хууль; MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага; Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам,
		Хог хаягдлыг ангилан ялгаж, гэрээт ААН (тохижилт үйлчилгээний ОНӨААТҮГ)-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх	Төслөөс гарах хог хаягдал	Жилд	0.2	12	2.4	2025 онд тогтмол сард нэг удаа	
		Ажилчдад хог хаягдлаа бууруулах, ангилан ялгах талаар дадал зуршил эзэмшүүлэх сургалт орох, мэдээллийн самбарт мэдээлэл байршуулах	Хог хаягдал түр хадгалах цэг	Жилд	0.5	2	1	2025 онд 2 удаа	

2.	Аюултай	Машин техникийн төмөр сэлбэг хэрэгсэл болон дугуйн хаягдлыг тусгай талбайд хуримтлуулан дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Төслийн хүрээнд	Жилд	-	1	Үйл ажиллагааны зардлаас	2025 онд тогтмол	
		Машин техникээс гарсан ШТМ, тос тосолгооны материалын сав баглаа боодол, ШТМ арчсан даавуу зэргийг аюултай хог хаягдлыг хадгалах, устгах цэг рүү зөөвөрлөх	Төслийн хүрээнд	Жилд	-	1	Үйл ажиллагааны зардлаас	2025 онд тогтмол	
	Нийт						3.4 сая/төг		

Хүснэгт 0-1 Хог хаягдлийн менежментийн төлөвлөгөө

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ)

Энэхүү “Чингэлэгт тээврийн терминалын талбай” төслийг хэрэгжүүлэх явцад БОННУ-ний тайлан, БОХТ-нд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.

Орчны хяналт шинжилгээний нэгдсэн хөтөлбөр нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нэг чухал хэсэг байдаг бөгөөд төслийн үйл ажиллагаа байгаль орчин, нутгийн иргэд, ажиллагсдын амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа эсэхийг хянах орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх удирдамж болдог.

Тус төслийг хэрэгжүүлэхэд баримтлан ажиллах орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төсөл хэрэгжих орчны байгалийн болон нийгэм эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, төслийн сөрөг нөлөөлөл, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөх зорилготой. Зардлын тооцоонд зөвхөн дээж сорьцыг авах болон түүнийг шинжлүүлэх лабораторийн шинжилгээний зардлыг тооцсон.

Чингэлэгт тээврийн терминалын талбай төслийн хувьд Монгол улсыг хилийн бүсэд, аймгийн тусгай хамгаалалттай газарт хамаарч байгаа тул төслийн ойр орчимд малтай өрх цөөн байгаа тул ОХШХ-ын үр дүнгийн талаар баг болон сумын иргэдэд тогтмол тайлагнадаг байх нь зүйтэй.

Төслийн үйл ажиллагааны явцад төлөвлөгдөөгүй судалгаа, хяналт шинжилгээний ажлууд гарч ирэхийг үгүйсгэх аргагүй юм. Төслийн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардал, түүний хуваарилалтыг жил бүр шинэчлэн тооцож байх шаардлагатай болно.

	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж ийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян. төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
Агаарын чанар								
1.	Тоосжилт (PM10, PM2.5); орчны дуу чимээ; Агаар бохирдуулагч хий NO2 ,SO2;	Салхины зонхилох чиглэл болон эх үүсвэрүүдийн байршил дахь агаар бохирдуулагчийн тархалтыг гаргахад төлөөлөх чадвартай 3 цэгт (Авто машины зогсоол, ажилчдын оффис, терминалын талбай орчимд)	Сар бүр	Жилд 12 удаа	-	-	Өөрийн тоос хэмжигч багаж	MNS3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага; MNS 4585:2016 Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS3384:1982. Агаар мандал-Агаарын дээжлэлт шинжилгээ; MNS3113:1981. Хорт утааны ялгаралтыг хэмжих арга; MNS5885-2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага; MNS0012-014:1991. Ажлын байрны агаар-Бичил орчинг шинжлэх арга; MNS0012-1-015:1987. Чимээ шуугиан–Ажлын байрны чимээ шуугианыг хэмжих арга; MNS0017.2.5.12:1988. Байгаль хамгаалал. Агаар мандал. Агаар дахь хүхэрлэг хийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга; MNS0017.2.5.11-1988. Байгаль хамгаалал. Агаар мандал. Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга; MNS5365:2004 Агаарын чанарын

								ерөнхий асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга;
Хөрсөн бүрхэвч								
1.	Ялзмаг, урвалын орчин (pH), давсжилт, карбонат (CaCO3), хөдөлгөөнт кали K2O), хөдөлгөөнт фосфор	Хогийн цэг, төслийн талбайн хатуу хучилтгүй талбай болон хашааны гадна талд нийт 3 цэгт	Жилд 1 удаа	1	100,000	300,000	Итгэмжлэгдсэн лабораторийн дэлгэрэнгүй шинжилгээ	MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам; MNS 3298-1991 Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд; MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
2.	Хар тунгалаг (Pb), кадми (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), Мөнгөн ус (Hg), цианид натри, хүнцэл (As)							
Амьтны аймаг								
	Шувууд, мөлхөгчид, хөхтөн амьтдыг ажиглах, тоо толгойг гаргах	Төслийн талбайд орчимд	Жилд 1 удаа	1			Ажиглалтын арга, Дуран, дижитал зургийн аппарат, байршил тогтоогч (GPS), судалгааны маягт ашиглах	Биологийн олон янз байдлын мониторинг судалгааны арга зүй. БОНХЯ, 2012

Гадаргын болон газрын доорх ус								
	Гадаргын болон газрын доорх усны чанар: Гол ионы найрлага: анион, катион, микро элементийн агууламж, Ундны усны микробиологийн хяналт шинжилгээ	- Унд ахуйн худгаас дээж авах - Ус цэвэршүүлэгчнээс дээж авах - Ахуйн бохир ус цэвэршүүлэгч байгууламжаас гарч буй уснаас дээж авах	Жилд 2 удаа	2	200,000	400,000	Хэмжилзүйн лабораторитай хамтран ажиллана	MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
			Нийт:			700,000		

Хүснэгт 0-1 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв сая.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			Сар				
	1	2	3	4	5	6	7
1.	Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний ажилтанд хариуцуулж, хяналт тавин ажиллах;	Цалингийн сангаас	Үйл ажиллагааны турш			Компанийн удирдлага	-
2.	Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах талаар тодорхой ажлуудыг тусган түүнийг мөрдөн ажиллах	1	Үйл ажиллагааны турш			Байгаль орчны мэргэжилтэн	-
3.	Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба тайлан боловсруулах, зохих төрийн захиргааны төв байгууллагуудад хянуулан батлуулж ажиллах		10	12	2	Байгаль орчны мэргэжилтэн	-
	Нийт	1					

Хүснэгт 0-1 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч “Монголын Алт (МАК)” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар тайланг БОУАӨЯ-д болон аймгийн байгаль орчны газарт хүргүүлнэ. Мөн БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны хяналтын улсын байцаагч, Засаг дарга болон бусад оролцогч талуудад танилцуулгыг жил тутам хийнэ.

№	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах,хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7	8
1	Төрийн захиргааны төв байгууллага /Байгаль Орчин, уур амьсгал өөрчлөлтийн яам/	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлсэн бичвэр байна.Тухайн бичвэр ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна.	Жил бүрийн 12 дугаар сарын 30- наас өмнө	100,000	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг баталгаажуулах	Удирдлага, байгаль орчны мэргэжилтэн	БОУАӨЯ-д
2	Өмнөговь аймгийн байгаль орчны газар	Тайлангийн эх хувь болон цахим хэлбэрээр албан бичгийн хамт		Жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс өмнө		Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж, санал авах		Өмнөговь аймгийн байгаль орчны газарт
3	Гурвантэс сумын ЗДТГ-т	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж танилцуулах		Жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс өмнө		Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах		Өмнөговь аймгийн Гурвантэс сумын ЗДТГ-т

Хүснэгт 0-1 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

№	Төсөв зохион байгуулалт	Дүн /сая.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	1.93
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	5
3	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	0.1
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3.4
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө	0.7
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	0.1
8	Нийт дүн /сая.төг/	12.23

Хүснэгт 0-1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зарда

Хүсэлтийн лавлах дугаар: S27186372202505053

Татсан огноо: 2025-05-05 15:26

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
8145101604 MN500015008145101604	100110455410	6,115,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр ШИВЭЭ ХҮРЭН ТЕРМИНАЛ	Хүлээн авагчийн нэр ӨМ.ГУРВАНТЭС БАРЬЦАА	Гүйлгээний утга БОМТ ТӨЛБӨР ШХТ 3649245,ӨМ.ГУРВАНТЭС БАРЬЦАА,Төрий	
	Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний огноо 2025-05-05	

